



Завхан аймгийн нийгэм, эдийн засгийн VIII сарын танилцуулга

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ /эхний VIII сар/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017	$\frac{2017}{2016}$ %	
<b>Нийгмийн статистикийн үзүүлэлт</b>					
Хүн амын амьжиргааны доод түвшин	мян.төг	164.2	164.8	100.3	
Төрсөн хүүхдийн тоо /амьд төрөлт/	хүн	1007	896	88.9	
Эхийн эндэгдэл	хүн	0	2		
Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо	хүн	503	357	70.9	
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо	хүн	951	1281	134.7	
Ажилд орсон хүний тоо	хүн	631	454	71.9	
Нийгмийн даатгалаас өндөр насны тэтгэвэр авагчдын тоо	хүн	9745	10032	102.9	
Олгосон тэтгэвэр, тэтгэмж	сая.төг	24346.9	24787.9	101.8	
Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	хүн	181	126	69.6	
<b>Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт</b>					
Татварын орлого	сая.төг	5685.7	6782.0	119.3	
Зээлийн хүү	хувь	0.58-2.8	0.58-2.0	-	
<b>Эдийн засгийн статистикийн үзүүлэлт</b>					
Нийт хураасан ургац, бэлтгэсэн өвс	тн	10418.3	5074.0	48.7	
Үүнээс	Төмс	тн	162.2	15.0	9.2
	Хүнсний ногоо	тн	54.02	3.9	7.2
	Ногоон тэжээл	тн	73.0	30.0	41.1
	Бэлтгэсэн өвс	тн	10129.1	5025.1	49.6
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт /бүгд/	сая.төг	7528.5	8374.3	111.2	
Үүнээс	Цахилгаан	сая.төг	1023.6	940.5	91.9
	Дулаан	сая.төг	1837.3	1795.8	97.7
	Усан хангамж	сая.төг	414.6	405.3	97.7
	Боловсруулах үйлдвэрлэл	сая.төг	4253.0	5232.7	123.0

## ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд эхний VIII сард 888 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 896 болж, өмнөх оноос амаржсан эх (11.5%)-аар, амьд төрсөн хүүхэд (11.0%)-аар буурсан байна. 2017 оны VIII сард 105 эх амаржиж, 106 хүүхэд төрүүлсэн нь өмнөх сараас амаржсан эх 18 (14.6%)-аар, хүүхэд мөн 19 (15.2%)-аар өссөн.

Нялхсын эндэгдэл эхний VIII сард 19 болж, өмнөх оноос 1 (5.5%)-ээр өссөн байна. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 21.2 болж, өмнөх оноос 3.4 пунктээр өссөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид эхний VIII сард 357 болж, өмнөх оны мөн үеэс 146 (29.0%)-аар буурахад энэ онд халдварт улаанбурхан өвчний тохиолдол бүртгэгдээгүй нь нөлөөлсөн байна.

Эхний VIII сард 11.4 мянган өвчтөнийг 87.8 мянган ор хоногоор хэвтүүлж эмчлэн, 231.1 мянган хүнд амбулаториор үйлчилж, 967 жирэмсэн эхийг шинээр хяналтанд авчээ.


## ХӨДӨЛМӨР

### Шинэ ажлын байр болон бүртгэлтэй ажилгүйчүүд

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1281 болж, өнгөрсөн оны мөн үеэс 34.7 хувиар буюу 330 хүнээр өссөн байна. Аймгийн хэмжээнд 688 эмэгтэй ажил идэвхитэй хайж байгаа нь ажилгүйчүүдийн 53.7 хувийг эзэлж байна.


2017 оны 8 сарын байдлаар бүртгүүлсэн, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 20.3 хувиар буюу 217 хүнээр өссөн байна.

### Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо /оноор/



Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 17.6 хувь нь 15-24 нас, 31.6 хувь нь 25-34 нас, 24.4 хувь нь 35-44 нас, 21.1 хувь нь 45-54 нас, 4.4 хувь нь 55-59 нас, 0.9 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна.

Ажилгүйчүүдийн 1.7 хувь нь боловсролгүй, 2.6 хувь нь бага, 7.3 хувь нь суурь, 50.0 хувь нь бүрэн дунд, 5.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 6.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 27.2 хувь нь дээд боловсролтой хүмүүс тус тус эзэлж байна.




### НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Аймгийн хэмжээгээр нийгмийн даатгалын сангаас эхний 8 сард 10.0 мянган хүнд 24.8 тэр бум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 9.9 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн байна.


Эхний 8 сард 11321 хүн нийгмийн даатгалд хамрагдсаны 8474 буюу 84.5 хувь нь төсөвт байгууллага, ААНэгж байгууллагын даатгуулагч, 2847 иргэн буюу 15.5 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан байна.

**Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая төгрөг**




Сангуудаар авч үзвэл: тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 4.4 хувиар, ҮОМШӨ сангийн орлогын төлөвлөгөөг 35.9 хувиар давуулан биелүүлж, тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 5.3 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 0.9 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 6.4 хувиар тасарсан байна.

**Нийгмийн даатгалын сангийн орлого, төрлөөр, хувиар**




Тэтгэвэрийн сангийн зарлага 21536.4 сая төгрөгт, Тэтгэмжийн сангийн зарлага 767.7 сая төгрөг, Эрүүл мэндийн сангийн зарлага 2066.4 сая төгрөг, ҮОМШӨ-ний зарлага 31.7 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалийн сангаас 385.7 сая төгрөг тус тус зарцуулж нийт 24787.9 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, даатгалыг олгосон байна.

**Нийгмийн даатгалын сангийн зарлага, төрлөөр, хувиар**



Халамжийн сангийн сангийн үйл ажиллагааны эхний 8 сарын мэдээгээр Халамжийн тэтгэвэр 1746 хүнд 1425.5 сая төгрөг, нөхцөлд мөнгөн тэтгэмж 9825 хүнд 1957.4 сая төгрөг, нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт 7901 хүнд 1119.9 сая төгрөг нийт 19472 хүнд 4502.8 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийг үзүүлсэн байна.

**Халамжийн сангийн зарцуулалт, сая төгрөг**



**ГЭМТ ХЭРЭГ**

Аймгийн хэмжээгээр эхний 8 сарын байдлаар 126 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 34.9 хувийг иргэдийн эрх чөлөө эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 34.9 хувь нь бусдын өмчлөлийн эсрэг гэмт хэрэг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэргийн тоо 55-аар буурсан байна.

Эхний 8 сард гэмт хэргийн улмаас 24 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс 4.8 дахин өссөн байна. Оны эхнээс өссөн дүнгээр 5027 зөрчил илрүүлж, 443 хүн эрүүлжигдэн, 162 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчил 1248, эрүүлжигдсэн хүн 37, баривчлагдсан хүн 124-өөр тус тус өсч, учирсан хохирол 57.3 сая, гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн 3-аар тус тус буурсан байна.

### ТАТВАРЫН ОРЛОГО

Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 114.9 хувийн биелэлттэй, 6 тэрбум 782.0 сая төгрөгийн орлого оруулсаны цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 45.4 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 3.3 хувь, ашигт малтмал ашигласаны төлбөр 21.0 хувь, бусад нэр төрөл 30.3 хувийг тус тус эзэлж байна. Нийт татварын орлогын бүрдүүлэлтийн 73.5 хувь буюу 4 тэрбум 986.5 сая төгрөгийг орон нутгийн орлого, 26.5 хувь буюу 1 тэрбум 795.5 сая төгрөгийг улсын төсвийн орлого бүрдүүлж байна.

### МӨНГӨ ЗЭЭЛ


Монгол банкны мэдээгээр эхний 8 сарын байдлаар гүйлгээнд 2 тэрбум 83.3 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжинд 64 мянган иргэний 67.9 тэрбум төгрөг байгаа нь иргэдийн мөнгөн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 8.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Аймгийн дүнгээр 85.4 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 4.5 хувь буюу 3.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Зээлийн сарын хүүг арилжааны банкуудаар авч үзвэл дунджаар ХААН банк 1.8%, Хас банк 0.58-2.0%, Төрийн банк 1.66%, Капитал банк 1.5% байна.


### ҮНЭ ХАНШ

9-р сарын 01-ний байдлаар баруун бүсийн аймгуудад 1л А-80 бензин 1550-1710, А-92 бензин 1700-1810, Дизелийн түлш 1650-1890, Улаанбаатар А-80 бензин 1480, А-92 бензин 1630 Дизелийн түлш 1720 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байна.


### ХӨДӨӨ АЖ АХУЙ

Аймгийн хэмжээнд 7 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны 1379.8 мянган хээлтэгч малын 1242,9 мянга (90,1%) нь төллөжээ. Гүүний 80,9 хувь, үнээний 83,4 хувь, ингэний 56,5 хувь, эм хонины 92,0 хувь, эм ямааны 89.3 хувь нь төллөж байна. Төллөлтийн хувь өмнөх оноос 2.8 пунктээр өссөн байна. Гарсан төлийн 97.6 хувь буюу 1214.2 мянган төл бойжиж байна. Төл бойжилтын хувь 2.9 пунктээр өссөн байна.





**Том малын зүй бус хорогдол:** Эхний 6 сард аймгийн дүнгээр 35.3 мянган том мал зүй бусаар хорогдсон нь оны эхний малын 1.0 хувь, нийт хорогдолд өвчний хорогдол 2.2 хувь, хээлтэгч малын хорогдол 16.1 хувь, бог малын хорогдол 89.6 хувийг тус тус эзэлж байна. Том малын зүй бусын хорогдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 91.2 мянгаар буюу 3.6 дахин буурсан байна.



### **УРГАЦ ХУРААЛТ, ХАДЛАН ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЛ**


9 сарын 1-ний байдлаар аймгийн дүнгээр төмс 15.0 тн, хүнсний ногоо 3.9 тн, ногоон тэжээл 30.0 тн, гар тэжээл 16.4 тн, байгалийн хадлан 5025.1 тн-ыг тус тус хураан аваад байна.

### **АЖ ҮЙЛДВЭР**

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 9 сарын 1-ний байдлаар оны үнээр 8374.3 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 11.2 хувиар буюу 845.8 сая төгрөгөөр өссөн байна. Нийт үйлдвэрлэлээс ААНэгжийн үйлдвэрлэл нь 4057.0 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 4317.3 сая төгрөг болсон байна. Үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 37.5%, хүнсний үйлдвэрлэл 37.2%, хувцас үйлдвэрлэл 13.1%, модон эдлэл үйлдвэрлэл 9.5%, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.7%, өлөн гэдэс үйлдвэрлэл



0.4%, Вакум цонх үйлдвэрлэл 0.5%, Барилгын ханын материал үйлдвэрлэл 0.6%, бусад үйлдвэрлэл 0.5%-ийг тус тус эзэлж байна.



ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн VIII сарын байдлаар

Хугацаа	Амаржсан эх	Амьд төрсөн хүүхэд	Нас баралт	Эхийн эндэгдэл	Нялхсын эндэгдэл	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл
2015 VIII	149	149	36	0	2	2
I-VIII	1104	1104	259	0	29	32
2016 VIII	138	139	27	0	2	3
I-VIII	1004	1007	259	0	18	22
2017 VIII	105	106	28	1	4	4
I-VIII	888	896	259	2	19	20

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээлэл

АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, НАС БАРАЛТ, сумаар, жил бүрийн эхний VIII сарын байдлаар

Сумын нэр	Амьд төрсөн хүүхэд						Нас баралт					
	2015		2016		2017		2015		2016		2017	
	VII	I-VIII	VII	I-VIII	VII	I-VIII	VII	I-VIII	VII	I-VIII	VIII	I-VIII
Алдархаан	3	26	6	34	6	25	2	11	2	11	1	8
Асгат	1	17	3	14	1	19	1	3	0	3	0	1
Баянтэс	8	39	3	43	2	23	3	10	0	4	1	13
Баянхайрхан	7	29	3	17	2	29	0	4	1	4	0	5
Тосонцэнгэл	9	152	19	124	12	129	6	32	4	40	3	42
Дөрвөлжин	3	25	5	19	3	17	0	4	0	8	0	4
Завханмандал	1	12	1	12	2	4	1	2	0	3	0	1
Идэр	3	33	1	32	6	33	0	9	2	8	0	10
Их-уул	11	104	6	70	11	70	2	23	2	22	1	21
Нөмрөг	3	17	5	27	2	15	0	3	0	9	1	4
Отгон	14	46	6	30	1	22	3	10	1	8	0	7
Сантмаргац	5	31	6	13	2	20	1	10	1	13	1	6
Сонгино	4	21	2	20	1	12	0	3	0	4	1	6
Түдэвтэй	4	21	4	32	3	22	2	7	0	10	2	7
Тэс	6	30	5	32	2	25	1	13	1	8	2	17
Тэлмэн	1	32	3	43	6	29	0	7	2	10	0	5
Ургамал	1	13	2	13	3	10	2	7	0	2	1	5
Улиастай	38	303	38	293	32	261	3	27	2	25	6	24
Цагаанхайрхан	3	17	4	16	1	11	0	1	1	7	2	6
Цагаанчулуут	2	10	1	7	1	10	0	4	1	4	0	3
Цэцэн-Уул	4	24	0	16	2	14	2	6	1	5	1	7
Шүлүүстэй	0	14	0	15	1	19	0	7	1	5	0	3
Эрдэнэхайрхан	1	21	6	23	1	15	0	5	0	1	1	10
Яруу	1	11	5	19	2	21	1	5	0	8	2	7
Бусад /ӨЭмнэлэг/	15	55	5	43	1	41	6	46	5	37	2	37
<b>ДҮН</b>	<b>148</b>	<b>1103</b>	<b>139</b>	<b>1007</b>	<b>106</b>	<b>896</b>	<b>36</b>	<b>259</b>	<b>27</b>	<b>259</b>	<b>28</b>	<b>259</b>

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээлэл

АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭ /VIII сарын байдлаар/

		Үзүүлэлт	/тоогоор/ 2017 он	
<b>Ажил хайгч иргэн /сарын эхэнд/</b>			<b>1288</b>	
Эмэгтэй			685	
<b>Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн</b>			<b>239</b>	
Эмэгтэй			118	
Шилжин суурьшсан			22	
Сургууль төгсөөд ажилгүй байгаа			58	
Сургуулиа орхисон /гарсан, чөлөө, авсан/			3	
Цэргээс халагдаад ажилгүй байгаа			5	
Гадаадаас эргэж ирсэн			1	
Хорих газраас суллагдсан			0	
Хөдөлмөрийн насанд хүрч асрамжийн газраас гарсан			0	
Ажил хайж байгаа шалтгаанаар	Одоо хөдөлмөр эрхэлж байгаа	Одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй	1	
		Ажлаас халагдах мэдэгдэл авсан	0	
		Өрхийн болон хувийн аж ахуйн нь эрсдэлд орж орлогогүй болсон	20	
		Цалин, орлого хүрэлцэхгүй байгаа	38	
		Нэмэлт цагаар ажиллах	1	
		Мэргэжил, ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх	36	
	Ажлаас чөлөөлөгдсөн /халагдсан/	Мэргэжилийн ур чадварын хувьд тэнцэхгүй болсон	0	
		Эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон	0	
		Тэтгэвэрт гарсан	0	
		Хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан	0	
		Орон тооны цомхотголд орсон	14	
		Байгууллага татан буугдсан	2	
	Бусад		38	
	<b>Тайлант хугацаанд хасагдсан иргэн</b>			<b>246</b>
	Ажилд зуучлагдан орсон иргэн			<b>9</b>
	Ажил хайж байгаа шалтгаанаар	Хариуцлагын хэлбэрээр	Хувьцаат компани	0
			Хязгаарлагдмал хариуцлагатай компани	6
			Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	0
Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл			0	
Хоршоо			0	
Төрийн өмчит үйлдвэрийн газар			0	
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар			0	
Төсөвт байгууллага			3	
Төрийн бус байгууллага			0	
Сан			0	
Бусад		0		
Насны бүлгээр		15-24	2	
		25-34	4	
		34-44	1	
	45-54	2		
	55-59	0		
	60+	0		
Боловсролын түвшингээр	Боловсролгүй	0		
	Бага	0		
	Суурь	0		
	Бүрэн дунд	2		
	Техникийн болон мэргэжлийн	0		
	Тусгай мэргэжлийн дунд	0		
	Дипломын болон бакалаврын дээд	7		
Магистр, доктор	0			
<b>Ажил хайгч иргэн /сарын эцэст/</b>			<b>1281</b>	
Эмэгтэй			688	

Эх сурвалж: /Аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр/

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, эхний VIII сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017	
	VII	I-VIII
<b>Нийгмийн даатгалын сангийн орлого, сая төгрөг</b>	<b>1204.7</b>	<b>9982.2</b>
Үүнээс:		
Тэтгэвэрийн даатгалын сангийн орлого	623.9	5764.4
Тэтгэмжийн сангийн орлого	70.6	648.8
Эрүүл мэндийн сангийн орлого	437.7	2902.6
ҮОМШӨ орлогын дүн	56.4	522.9
Ажилгүйдлийн даатгалын сан орлого	16.1	143.5
<b>Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая төгрөг</b>	<b>1401.9</b>	<b>24787.9</b>
Үүнээс:		
Тэтгэвэрийн сангийн зарлага	856.4	21536.4
Тэтгэмжийн сангийн зарлага	116.8	767.7
Эрүүл мэндийн сангийн зарлага	325.2	2066.4
ҮОМШӨ зарлагын дүн	5.2	31.7
Ажилгүйдлийн даатгалын сан зарлага	98.3	385.7

Эх үүсвэр: Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээлэл  
 ҮОМШӨ - Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР,  
ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, эхний 8 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	Хүний тоо
	2017 I-VIII
<b>Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж</b>	<b>19472</b>
Халамжийн тэтгэвэр	1746
<b>Нөхцөлт мөнгөн тэтгэмжийн дүн</b>	<b>9825</b>
Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн НМТ	1836
Ахмад настанг асарч буй иргэнд НМТ	718
ХБ-тэй иргэнийг асарч буй иргэнд НМТ	497
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт тусламж	502
Алдарт эхийн одонтой ахмадуудад олгосон мөнгөн тусламж	6272
<b>Нийгийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтийн дүн</b>	<b>7901</b>
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт үйлчилгээ	32
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн хөнгөлөлт үйлчилгээ	384
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	658
Хүнс тэжээл хөтөлбөр	3460
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн	75
Насны хишиг	3292

Үзүүлэлтүүд	Зардал /сая.төг/
	2017 I-VII
<b>Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж</b>	<b>4502.8</b>
Халамжийн тэтгэвэр	1425.5
<b>Нөхцөлт мөнгөн тэтгэмжийн дүн</b>	<b>1957.4</b>
Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн НМТ	309.5
Ахмад настанг асарч буй иргэнд НМТ	345.5
ХБ-тэй иргэнийг асарч буй иргэнд НМТ	261.1
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт тусламж	188.9
Алдарт эхийн одонтой ахмадуудад олгосон мөнгөн тусламж	846.4
<b>Нийгийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтийн дүн</b>	<b>1119.9</b>
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт үйлчилгээ	36.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн хөнгөлөлт үйлчилгээ	64.1
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	216.6
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	25.1
Хүнс тэжээл хөтөлбөр	264.8
Насны хишиг	512.6

Эх үүсвэр: Аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээлэл

ГЭМТ ХЭРЭГ

Хэргийн төрөл	2016	2017	2017	
			2016	%
<b>Бүртгэгдсэн хэрэг</b>	<b>181</b>	<b>126</b>	<b>69.6</b>	
ИЭЧЭМ-эсрэг	74	44	59.5	
Хүчин	5	3	60.0	
Бусдын өмчийн хулгай	70	44	62.9	
үүнээс: малын хулгай	11	7	63.6	
Иргэдийн өмчийн хулгай	59	37	62.7	
Танхай	3	5	166.7	
Булаах	-	-	-	
Дээрэмдэх	-	-	-	
Залилан	5	1	20.0	
Тээврийн хэрэгсэл, хөдөлгөөн аюулгүй байдал	11	11	100.0	
Бусад	13	18	138.5	
Гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо	5	24	4.8 <sup>2</sup>	
Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний тоо	58	55	94.8	
Учирсан хохирол /сая.төг/	279.7	222.4	79.5	
Гарсан зөрчил	3779	5027	133.0	
Эрүүлжүүлэгдсэн	406	443	109.1	
Баривчлагдсан	38	162	4.2 <sup>2</sup>	

<sup>2</sup> -дахин их

Эх сурвалж: Аймгийн Цагдаагийн газрын мэдээгээр

ТАТВАРЫН ОРЛОГО

	эхний VIII сар				сая.төг
	2016 он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	2017 2016
	1.Хүн ам орлогын албан татвар	431.9	399.3	624.4	156.4
2.Цалин хөлстэй адилтгах бусад ОАТ	3088.6	3370.7	3077.8	91.3	99.7
3.Үл хөдлөх хөрөнгийн татвар	53.5	58.8	62.8	106.8	117.4
4.Авто машин өөрөө явагч хэрэгслийн албан татвар	249.7	225.8	260.0	115.1	104.1
5.Усны нөөц ашигласны төлбөр	43.1	141.0	213.9	151.7	4.9 <sup>2</sup>
6. Газрын төлбөр	116.7	114.0	120.4	105.6	103.2
5.Бусад татвар, төлбөр хураамж	289.8	324.3	295.8	91.2	102.1
Үүнээс: Улсын тэмдэгтийн хураамж	131.3	132.2	101.9	77.1	77.6
Ой ашигласаны төлбөр	93.9	124.3	96.0	77.2	102.2
Ан амьтан агнах, барих	1.5	0.0	8.7	-	5.8 <sup>2</sup>
Бусад	63.1	67.8	89.2	131.6	141.4
6.Татварын бус орлого	267.2	215.2	331.4	154.0	124.0
Хүү торгуулийн орлого	13.0	36.1	20.4	56.5	156.9
Бусад	254.2	179.1	311.0	173.6	122.3
7. ХХОАТ-ын буцаан олголт	0.0	0.0	0.0	-	-
<b>8.Орон нутгийн орлого /бүгд/</b>	<b>4540.5</b>	<b>4849.1</b>	<b>4986.5</b>	<b>102.8</b>	<b>109.8</b>
ААНБ-ын албан татвар	66.9	75.8	71.0	93.7	106.1
НӨАТ	292.8	357.4	225.7	63.2	77.1
Онцгой	57.1	55.7	48.3	86.7	84.6
Агаарын бохирдлын төлбөр	24.1	24.0	27.6	115.0	114.5
Ашигт малтмал ашигласны төлбөр	704.3	541.0	1422.9	2.6 <sup>2</sup>	2.2 <sup>2</sup>
<b>9.Төвлөрсөн төсөвт орсон орлого /бүгд/</b>	<b>1145.2</b>	<b>1053.9</b>	<b>1795.5</b>	<b>170.4</b>	<b>156.8</b>
<b>Дүн</b>	<b>5685.7</b>	<b>5903.0</b>	<b>6782.0</b>	<b>114.9</b>	<b>119.3</b>

Эх сурвалж: Аймгийн татварын хэлтсийн мэдээгээр

<sup>2</sup> дахин их

Завхан аймгийн нийгэм, эдийн засгийн VIII сарын танилцуулга

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /аймаг, нийслэлээр, жил, сар/

Аймаг	Хонины мах		Үхрийн мах		Ямааны мах	
	VII дундаж үнэ	VIII.30	VII дундаж үнэ	VIII.30	VII дундаж үнэ	VIII.30
Баян-Өлгий	5 389	4 666	4 500	4 333	4 583	4 000
Говь-Алтай	5 367	4 200	6 500	5 000	4 433	3 500
Завхан	5 867	5 000	6 000	5 500	4 500	4 000
Увс	5 500	5 000	5 500	5 000	3 667	3 000
Ховд	6 000	5 500	6 000	6 000	5 000	5 500
Архангай	5 567	5 000	6 667	5 800	4 500	4 300
Баянхонгор	5 200	4 500	6 167	5 500	4 533	3 800
Булган	5 833	5 000	6 833	6 000	4 833	4 500
Орхон	6 089	5 000	6 978	6 500	4 833	4 500
Өвөрхангай	5 667	4 600	6 600	5 800	4 600	3 800
Хөвсгөл	6 167	6 000	7 000	6 500	5 500	5 000
Говьсүмбэр	5 500	5 000	7 000	6 500	5 000	4 500
Дархан-Уул	6 261	5 650	7 350	6 600	5 500	5 000
Дорноговь	5 556	5 500	8 722	8 500	4 556	4 667
Дундговь	5 000	4 800	-	-	4 600	4 000
Өмнөговь	5 750	5 250	-	-	5 417	4 650
Сэлэнгэ	5 867	5 500	6 933	6 300	5 167	5 000
Төв	6 500	5 500	7 833	7 250	5 167	4 500
Дорнод	6 000	5 300	7 000	6 167	5 500	4 600
Сүхбаатар	5 500	5 500	7 167	6 500	4 500	4 500
Хэнтий	7 000	6 000	9 000	7 500	5 500	5 500

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /аймаг, нийслэлээр, жил, сар/

Аймаг	1-р зэргийн гурил		Элсэн чихэр		Цагаан будаа		Сүү /савлаагүй/	
	VII дундаж үнэ	VIII.30	VII дундаж үнэ	VIII.30	VII дундаж үнэ	VIII.30	VII дундаж үнэ	VIII.30
Баян-Өлгий	893	960	2 400	2 400	2 500	2 500	1 288	1 700
Говь-Алтай	1 300	1 300	2 500	2 500	2 300	2 300	1 600	1 800
Завхан	1 040	1 040	2 200	2 200	2 200	2 300	1 500	1 500
Увс	1 033	1 233	2 355	2 366	2 411	2 400	789	1 000
Ховд	1 300	1 300	1 900	1 900	2 200	2 200	1 200	1 500
Архангай	1 250	1 250	2 300	2 300	2 500	2 500	1 400	1 500
Баянхонгор	1 200	1 200	2 200	2 000	2 200	2 200	1 500	1 500
Булган	1 500	1 500	2 500	2 500	2 500	2 500	1 000	1 000
Орхон	1 100	1 100	2 267	2 200	2 200	2 267	867	1 000
Өвөрхангай	1 200	1 200	2 300	2 200	2 300	2 200	1 367	1 500
Хөвсгөл	1 300	1 300	2 233	2 200	2 300	2 300	1 000	1 200
Говьсүмбэр	1 200	1 300	2 200	2 200	2 133	2 200	1 000	1 000
Дархан-Уул	1 020	1 075	2 350	2 333	2 350	2 350	767	800
Дорноговь	984	1 083	2 133	2 133	2 100	2 100	1 667	1 500
Дундговь	1 200	1 200	2 300	2 300	2 200	2 200	2 000	1 500
Өмнөговь	1 250	1 367	2 222	2 200	2 256	2 267	2 500	2 250
Сэлэнгэ	1 250	1 250	2 200	2 200	2 300	2 100	667	800
Төв	1 200	1 100	2 200	2 200	2 200	2 200	1 000	1 000
Дорнод	920	920	2 100	2 000	2 200	2 200	600	800
Сүхбаатар	1 233	1 233	2 222	2 133	2 167	2 200	1 000	1 000
Хэнтий	1 100	1 100	2 200	2 200	2 233	2 300	1 000	1 000



ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ аймаг, нийслэлээр, жил сар

Аймаг	А-80		Аи-92		ДТ	
	2016 VIII.31	2017 VIII.30	2016 VIII.31	2017 VIII.30	2016 VIII.31	2017 VIII.30
Баян-Өлгий	1 370	1 550	1 520	1 700	1 390	1 650
Говь-Алтай	1 450	1 650	1 550	1 750	1 550	1 850
Завхан	1 550	1 650	1 660	1 760	1 740	1 890
Увс	1 550	1 603	1 660	1 760	1 790	1 843
Ховд	1 510	1 710	1 610	1 810	1 550	1 850
Архангай	1 510	1 550	1 690	1 660	1 790	1 750
Баянхонгор	1 480	1 570	1 580	1 680	1 690	1 770
Булган	1 450	1 500	1 550	1 650	1 650	1 750
Орхон	1 473	1 500	1 587	1 650	1 690	1 750
Өвөрхангай	1 450	1 550	1 530	1 660	1 600	1 770
Хөвсгөл	1 570	1 570	1 780	1 780	1 840	1 840
Говьсүмбэр	1 476	1 493	1 610	1 696	1 696	1 750
Дархан-Уул	1 450	1 480	1 522	1 616	1 628	1 702
Дорноговь	1 463	1 557	1 643	1 737	1 713	1 767
Дундговь	1 490	1 540	1 670	1 720	1 750	1 750
Өмнөговь	1 530	1 580	1 710	1 780	1 760	1 820
Сэлэнгэ	1 480	1 480	1 580	1 630	1 690	1 720
Төв	1420	1 480	1470	1 630	1550	1 720
Дорнод	1 550	1 570	1 660	1 680	1 790	1 810
Сүхбаатар	1 580	1 630	1 690	1 740	1 820	1 870
Хэнтий	1 540	1 540	1 650	1 700	1 750	1 800

УРГАЦ ХУРААЛТ, ХАДЛАН ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЛИЙН ЯВЦЫН МЭДЭЭ

2017.09.01

/ тн /

Сумын нэр	Төмс		Хүнсний ногоо		Хадлан		Гар тэжээл		Ногоон тэжээл	
	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017
Улиастай	130.2	4.5	50.8	1.8	80.0	10.2			33.0	4.0
Алдархаан					2810.0	1575.0				
Асгат					55.0	293.0				
Баянтэс					1821.0	589.0				
Баянхайрхан					590.0	300.0				
Дөрвөлжин			0.5	0.4	17.7	28.5		0.5		
Завханмандал					15.0	8.0		2.0		
Идэр					440.0	29.5				
Их Уул					876.3	193.8				
Нөмрөг					275.0	332.0				
Отгон					110.0	117.0				
Сантмаргац					0.0	0.0				
Сонгино					245.0	59.0	17.0	6.4		
Тосонцэнгэл	32.0	15.0	2.7	3.4	200.0	7.0			20.0	6.0
Түдэвтэй					579.5	251.5				
Тэлмэн					600.0	350.0				
Тэс					440.0	237.0				
Ургамал					80.5	37.8		0.5		
Цагаанхайрхан					198.0	155.0				
Цагаанчулуут					147.1	70.0				
Цэцэн уул					0.0	0.0				
Шилүүстэй					253.0	313.8				
Эрдэнэхайрхан					110.5	10.0				
Яруу				0.1	185.5	58.0	5.1	7.0	20.0	20.0
<b>Дүн</b>	<b>162.2</b>	<b>15.0</b>	<b>54.0</b>	<b>3.9</b>	<b>10129.1</b>	<b>5025.1</b>	<b>22.1</b>	<b>16.4</b>	<b>73.0</b>	<b>30.0</b>

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, /дэд салбараар, өссөн дүнгээр /  
/ сая, төг /**

Аж үйлдвэрийн салбар	2013	2014	2015	2016	2017	үүнээс	
						ААНэгж	иргэд
<b>Нийт дүн</b>	7301.9	7427.3	6658.1	7528.5	8374.3	4057.0	4317.3
<b>Боловсруулах үйлдвэр</b>	<b>2104.1</b>	<b>3093.9</b>	<b>2998.7</b>	<b>4253.0</b>	<b>5232.7</b>	915.4	4317.3
<b>Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</b>	<b>1368.6</b>	<b>1383.7</b>	<b>1517.5</b>	<b>1795.5</b>	<b>3116.6</b>	652.4	2464.2
Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	17.2	6.0	3.3	2.5	711.9	1.9	710.0
Нарийн боов, талх, чихэр үйлдвэрлэл	1188.5	1288.7	1170.8	1296.6	1825.4	141.8	1683.6
Хиам	1.7	-	4.7	10.0	27.5	27.5	
Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	147.6	76.3	286.9	410.0	507.8	457.4	50.4
Хэрчсэн гурил	-	-	26.6	67.5	11.4		11.4
Давс олборлолт, иоджуулсан давс	13.6	12.7	25.2	8.9	23.3	23.3	
Цай үйлдвэрлэл					9.3	0.5	8.8
Гутал, хувцас үйлдвэрлэл /оёдол/	336.5	873.2	558.1	1518.0	1096.1	58.7	1037.4
Модон эдлэл үйлдвэрлэл	224.5	563.8	439.9	718.6	792.5	134.9	657.6
Блок, тоосго	58.9	225.8	206.9	98.2	48.1		48.1
Гурил үйлдвэрлэл	74.1	17.7	73.4	-	-		
Боловсруулсан мах	-	-	132.0	-	-		
Өлөн гэдэс үйлдвэрлэл					31.9	31.9	
Эсгий, эсгий эдлэл үйлдвэрлэл	16.9	6.5	30.9	60.5	61.0	37.5	23.5
Вакум цонх					42.3		42.3
Бусад /төмөр/	24.9	23.2	40.0	62.2	44.2		44.2
<b>Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж</b>	<b>5013.3</b>	<b>4131.0</b>	<b>3556.0</b>	<b>3034.6</b>	<b>3141.6</b>	3141.6	
Цахилгаан үйлдвэрлэл	3635.4	2531.9	1648.5	1023.6	940.5	940.5	
Дулаан үйлдвэрлэл	1311.2	1595.7	1581.9	1837.3	1795.8	1795.8	
Усан хангамж	250.9	205.8	429.0	414.6	405.3	405.3	

Завхан аймгийн нийгэм, эдийн засгийн VIII сарын танилцуулга

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН /дэд салбараар/

/Сая төгрөг/

Хугацаа	Нийт дүн	Боловсруулах аж үйлдвэр	Цахилгаан, дулааны эрчим үйлдвэрлэл, усан хангамж	
2014	I	990.9	493.4	497.5
	II	1105.9	217.5	888.4
	III	1173.5	236.3	937.2
	IV	1177.1	238.2	938.9
	V	1031.5	415.6	615.9
	VI	652.3	462.7	189.6
	VII	779.8	716.3	253.1
	VIII	516.3	313.9	202.4
	<b>I-VIII</b>	<b>7427.3</b>	<b>3093.9</b>	<b>4333.4</b>
2015	I	1275.5	455.9	819.6
	II	1353.4	557.6	795.8
	III	1269.1	488.1	781
	IV	899	221.1	677.9
	V	481.9	234.5	233.9
	VI	348.8	217.8	144.5
	VII	543.2	439.9	103.3
	VIII	487.2	383.8	103.4
	<b>I-VIII</b>	<b>6658.1</b>	<b>2998.7</b>	<b>3556</b>
2016	I	1678.3	908.9	769.4
	II	1009.3	279.1	730.2
	III	1144.4	446.3	698.1
	IV	1096.5	563	533.5
	V	601.4	506	95.4
	VI	791.7	675.8	115.9
	VII	587.5	495.4	92.1
	VIII	619.4	378.5	240.9
	<b>I-VIII</b>	<b>7528.6</b>	<b>4253</b>	<b>3034.6</b>
2017*	I	964.3	288.8	675.8
	II	1818.9	1101.4	717.2
	III	903.1	192.3	710.8
	IV	769.8	200.8	569
	V	386.1	264.2	121.9
	VI	426.6	313.8	112.8
	VII	1804.4	1744.2	173
	VIII	1301.1	750.8	173.9
	<b>I-VIII</b>	<b>8374.3</b>	<b>5232.7</b>	<b>3141.6</b>
	<u>2017I – VIII</u>			
	<u>2016I – VIII</u>	75	123	103.5
	<u>2017 VIII</u>			
	<u>2016 VIII</u>	210	198.3	72.2
	<u>2017 VIII</u>			
	<u>2016 VII</u>	72.1	43	100.5

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, өссөн дүнгээр

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	үүнээс	
							ААНэгж	иргэд
<b>Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж</b>								
Цахилгаан эрчим хүч	мян.квт.ц	9649.9	5057.9	3347.3	3528	3314.5	3314.5	
Дулааны эрчим хүч	мян.г.кал	114.8	139.7	138.5	160.8	155.6	155.6	
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>								
Савхин гутал	хос	1066.0	1339.0	1185.0	1772.0	530.0	530.0	
Хүүхдийн гутал	хос	218.0	208.0	263.0	686.0	223.0	223.0	
Монгол гутал	хос	4373.0	9256.0	4638.0	1180.0	568.0	53.0	515.0
Монгол дээл/зөөлөн оёдол/	ширхэг	4373.0	9256.0	4638.0	11488.0	2974.0	828.0	2146.0
Талх	тонн	372.3	280.6	206.6	248.1	179.1	12.0	167.1
Нарийн боов	тонн	380.7	436.6	309.0	324.5	190.5	23.1	167.4
Чихэр	тонн	2.8	5.2	3.2	1.7	5.4	5.4	
Архи, дарс	мян.л	31.1	16.8	29.4	27.6	34.3	34.3	
Ундаа ,Хийжүүлсэн ус	мян.л	7.3	10.7	86.5	352.1	194.8	194.8	
Хаим	тонн	0.3	0.0	0.8	1.9	5.0	5.0	
Ус борлуулалт	мян.куб.м	126.6	102.9	143.0	138.2	104.9	104.9	

